

## ЭМГЭНЭЛ

### Ярослав Вацек (1943-2017)

Нэйт монголч эрдэмтэн, БНЧУ-ын Карлын их сургуулийн профессор Ярослав Вацек таалал төгсч, дэлхийн монгол судлал, шинжлэх ухааны ертөнцөд хүнд гарз тохиолоо. Я.Вацек Улаанбаатар хотод монгол хэл сурсныхаа дараа Карлын их сургуульд монгол судлалын сургалтыг эхлүүлж, 1976 оноос эхлэн монгол хэлний мэргэжлийн ангийг тус сургуулийн Философийн факультетэд нээсэн билээ. Ийнхүү дэлхийн монгол судлалын хүчтэй төвүүдийн нэг Карлын их сургуулийн монгол судлал шинжлэх ухааны үндэстэй, албан ёсны дэмжлэгтэй хөгжих баттай суурийг тавьсан гавьяатай хүн бол Я.Вацек юм.

Тэрбээр 1989 он хүртэл монгол хэл заахын зэрэгцээ монгол хэлний сурх бичиг зохиох, монгол хэл болон алтайн олон хэлийг дравид хэлтэй зэрэгцүүлэн судлах зэргээр сургалт, судалгааны ажилд идэвхтэй оролцож байв. Я.Вацек 1993-2003 онд Карлын Их сургуулийн Философийн факультетын Энэтхэг судлалын хүрээлэнгийн захирал, 2003-2006 онд Карлын их сургуулийн Философийн факультетын декан, 2006-2014 онд Философийн факультетын Өмнөд ба төв Ази судлалын хүрээлэнгийн захирал зэрэг албыг хаших хугацаанд тус сургуульд монгол судлалын сургалт, судалгааг тасралтгүй хөгжүүлэх үйлсийг оройлон манлайлж, Чехийн монгол судлалын тулах багана болж байлаа. Профессор Я.Вацек олон монгол судлаачдыг төрүүлэн гаргасан бөгөөд түүний шавь нар монгол судлалын шинжлэх ухааны салбар, дипломат албанд ажиллаж байна. Тэрбээр Олон улсын монгол судлалын идэвхтэй гишүүн байсан төдийгүй монгол судлалыг түгээн дэлгэрүүлэх үйлсийг манлайлагч, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтдийн нэг байлаа. Ярослав Вацекийн монгол судлалыг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2010 онд “Найрамдал” одонгоор шагнажээ.

Профессор Ярослав Вацек таалал төгссөнд Монгол Улсын Гадаад харилцааны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Ерөнхий сайдын дэргэдэх Монгол судлалын үндэсний зөвлөл, Шинжлэх ухааны академи, Олон улсын монгол судлалын холбооноос гүн эмгэнэл илэрхийлж байна. Талийгаачийн эрдэм номын үйл мөнхөд алдаршиж, монгол судлалын хөгжилд оруулсан хувь нэмэр үүрд дурсагдах болно.

Монгол Улсын  
Гадаад харилцааны яам

Монгол Улсын Боловсрол,  
соёл, шинжлэх ухаан,  
спортын яам

Монгол Улсын Ерөнхий  
сайдын дэргэдэх Монгол  
судлалын холбоо

Монгол Улсын  
Шинжлэх ухааны академи

Олон улсын монгол  
судлалын холбоо